

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 04

№ Т/53

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дүгээр зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12, “Эм жи эл акуа” ХК-ийн дүрмийн 6.4, 7.21.13 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Эм жи эл акуа” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд үндэслэн 2026 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.
2. Энэ тогтоолын 1-т заасан шийдвэрийн үндэслэлийг компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудит эрсдлийн хороонд /Ч.Анхбаяр/ даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Л.БИЛГҮҮН /

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 04

№ Т/54

Улаанбаатар хот

ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН
БАЙГУУЛЛАГЫГ СОНГОХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10, “Эм жи эл акуа” ХК-ийн дүрмийн 7.21.11 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Эм жи эл акуа” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “ПИ КЭЙ ЭФ – АЙ ЭЙ ЭС Аудит” ХХК-г сонгосугай.
2. “ПИ КЭЙ ЭФ – АЙ ЭЙ ЭС Аудит” ХХК-тай байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулахыг гүйцэтгэх захирлын орлогч /Б.Бат-Оргил/-д зөвшөөрсүгэй.
3. Хөндлөнгийн Аудитын дүгнэлтийг ТУЗ-ийн дэргэдэх Аудит эрсдлийн хороонд танилцуулахыг гүйцэтгэх захирлын орлогч /Б.Бат-Оргил/-д үүрэг болгосугай.
4. “ПИ КЭЙ ЭФ – АЙ ЭЙ ЭС Аудит” ХХК – тай байгуулах гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх захирлын орлогч Б.Бат-Оргил, ерөнхий нябо Д.Бат-Ирээдүй нарт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

 / Л.БИЛГҮҮН /

